



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 1/193

Улаанбаатар хот

Шинжээч томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.26, 4.1.12, 48.4, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол-Энэтхэгийн Засгийн газар хооронд байгуулсан 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн тайланг хянан үзэж, шүүмж хийж, нэгдсэн дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчийн хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Тушаалын хавсралтаар томилогдсон шинжээчдийн ажлын хөлсийг холбогдох аргачлалаар тооцон олгож, тайлантай холбоотой бүхий л мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгч "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-д даалгасугай.


3. Шинжээчийн хэсгийн нэгдсэн шүүмж, дүгнэлтийн үнэн бодит байдалд хяналт тавин ажиллаж "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг холбогдох дүрэм, журмын дагуу Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхийг Уул уурхайн бодлогын газрын дарга Б.Дэлгэржаргал, Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Даваадорж, Метал бус үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Б.Анхбаяр нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД  Д.СУМЬЯАБАЗАР



08 0528

Уул уурхай, хүнд үйлдвэрийн  
сайдын 2018 оны 10 дугаар  
сарын 11-ний өдрийн 11/83 дугаар  
тушаалын нэгдүгээр хэсрэлт



### ШИНЖЭЭЧИЙН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Овог, нэр	Албан тушаал, эрдмийн зэрэг, цол	Утасны дугаар	Үнэлэлт, дүгнэлт өгөх ТЭЗҮ
1.	Х.Наранхүү	Эдийн засагч	90081015	Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжүүлэх "Жилд 1.5 сая тн газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн техник, эдийн засгийн үндэслэл
2.	Ц.Багмид	Газрын тосны инженерүүдийн нийгэмлэг доктор (Ph.D), Монгол Улсын зөвлөх инженер	99298023	
3.	Г.Тунгалагтамир	Дэд профессор, доктор (Ph.D) Газрын тосны зөвлөх инженер	88116045	
4.	Д.Алтанцэцэг	Доктор (Ph.D), Монгол Улсын зөвлөх инженер	99099263	